

**“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХХК -ИЙН  
ҮЙЛДВЭРИЙН ОРЧНЫ ХЯНАЛТЫН КАМЕРЖУУЛАЛТЫН  
НЭГДСЭН СИСТЕМ БИЙ БОЛГОХ ТЕНДЕРИЙН  
АЖЛЫН ДААЛГАВАРТ ТУСГАГДСАН**

**Үйлдвэр барилга, байгууламжийг камержуулах зураг, төсвийн ерөнхий шаардлагын**

2. Хяналтын камерын дотоод сүлжээ, шилэн кабель болон цахилгаан тэжээлд холбох сүлжээний топологи зураг гаргасан байх.
3. Хяналтын камеруудын цахилгааны тэжээлийг тусад нь татсан байх. Холболтын хайрцаг руу цахилгааны инженертэй зөвшилцөж 24/7 цагаар тасалдахгүй байхаар тооцоолж цахилгааны утсыг хар хоолойнд хийж цахилгаан тэжээлд холбосон байх зураг гаргасан байх.
5. Компанийн хэмжээнд одоо ашиглаж байгаа камерын судалгаанд үндэслэн мэргэшсэн төсөвчнөөр баталгаажсан материалын түүвэр техникийн тодорхойлолт гаргасан байх.

**Үйлдвэр барилга, байгууламжийг камержуулах сүлжээ холболтын ерөнхий шаардлагын**

9. Хяналтын камерын сүлжээ холболтын барилга байгууламжийн гадна дотор орчинд 100 м хүртэлх урттай зайнд Hikvision эсхүл түүнтэй дүйцэх STP CAT6 төрлийн гадна зориулалтын кабелийг зориулалтын хамгаалалтын хар хоолойнд хийж татсан байх.
13. Кабель татах боломжгүй онцгой байрлалд камер суурилуулах шаардлага гарвал радио долгионы антен Ubiquiti Rocket M5 access point эсхүл түүнтэй дүйцэх NANO STATION ашиглаж болно. Энэ үед радио долгион нь гаднын нөлөөлөлд өртөхөөргүй байхаар тооцоолж суурилуулалт хийсэн байх.
14. Хяналтын камерын сүлжээ холболтыг 100м-ээс дээш урт зайнд агаарын эсвэл сувагчлалын 12-өөс доошгүй шөрмөстэй шилэн кабелийг дагалдах төхөөрөмжүүдийн хамт хэрэглэсэн байх. Агаараар татах тохиолдолд уян ган троосонд багцалж, төгсгөлийг газардуулсан холбооны хайрцагтай байх.
21. Сүлжээний зангилаа цэгт байрлах сүлжээний төхөөрөмжүүдийг цахилгааны хэлбэлзэл, тасалдлаас хамгаалах цахилгааны болон сүлжээний төхөөрөмжүүд хэвийн ажиллах цахилгааны найдвартай эх үүсвэр оруулж цахилгааны тэжээлийг тусад нь татаж 30 доошгүй минут барих тог баригчийг холболтын хайрцаг тус бүрд суурилуулж хамгаалсан байна.

**Онцгой нөхцөлийн**

1. Холбоо дохиоллын ажлыг “Тавантолгой түлш” ХХК-ийн ерөнхий төлөвлөгөө зургийн дагуу үйлдвэрийн дарга, ерөнхий инженер, захиалагчийн хяналт, мэдээлэл технологийн хэлтсийн инженерүүдтэй зөвшилцөж үйлдвэрийн орчин нэгдсэн системтэй уялдуулж зураг материалын түүвэр гаргаж ажлыг гүйцэтгэнэ.
7. Тухайн ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийн хяналт, мэдээлэл технологийн холбоо, дохиоллын инженерүүдтэй хамтран ажиллах.

Дээрх заалтуудыг үндэслэн тодруулгын хариу хүргүүлж байна.